

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын нэр:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

**Аудитын код:** ХЭА-2024/12-22-ШТА-НА

**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор**  
**Ж.Ганбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

**Аудитын менежер Д.Оюунтуяа**

Утас: 99775390 Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

**Ахлах аудитор Ц.Билэгсайхан**

Утас: 88032817 Цахим хаяг: [bilegsaikhants@audit.gov.mn](mailto:bilegsaikhants@audit.gov.mn)

**Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг**

Утас: 88470096 Цахим хаяг: [erdenebilegd@audit.gov.mn](mailto:erdenebilegd@audit.gov.mn)

**Аудитор Т.Алтаншагай**

Утас: 99818959 Цахим хаяг: [altanshagait@audit.gov.mn](mailto:altanshagait@audit.gov.mn)

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт .....	2
Ерөнхий зүйл .....	3
<i>Бүлэг 1. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагад сонгуулийн дансаа бүртгүүлэх үүргээ нийт намын хорооны 79.5 хувь нь биелүүлээгүй, нэр дэвшигчдэд өгсөн зөвшөөрөгдөөгүй хандивын 48.3 хувийг буцаан шилжүүлээгүй байна.....</i>	5
1.1. Нийт нэр дэвшигчдийн 98 хувь нь сонгуулийн зардлын дансаа бүртгүүлж, дээд хэмжээнээс хэтэрсэн хандив аваагүй байна. ....	5
1.2. Хуульд заасан шаардлага хангаагүй нийт хандивын 48.3 хувийг буцаан шилжүүлэхгүй сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.....	6
<i>Бүлэг 2. Сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу тайлагнасан байна. ....</i>	7
2.1. Нэр дэвшигчдийн 97.1 хувь нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн дагуу гаргаж ирүүлсэн бол намын хороодын 77.8 хувь нь сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна. ....	7
2.2. Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг оролцогч талууд хууль, журмын дагуу гаргаж ирүүлсэн байна.....	8
Аудитын дүгнэлт .....	9
Тайланг баталгаажуулсан тушаал .....	10

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх /ХЭА-2024/12-22-ШТА-НА/

### Товчилсон үгийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГ	ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит

## Ерөнхий зүйл

### Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### Аудитын зорилт

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд чиглэсэн. Үүнд:

- ❖ Сонгуулийн зардлын санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулсан эсэх
- ❖ Сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу бүрэн тайлагнасан эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хийсэн хувийн аудитын хуулийн этгээдийн дүгнэлт, банканд байршуулсан сонгуулийн зардлын дансны гүйлгээний хуулгыг хамруулан гүйцэтгэлээ.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн аудитын арга зүйг ашиглан баримт материалд үндэслэн тулган баталгаажуулалт хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгаж дүгнэлт гаргав.

### Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, хүлээн авах, нийтэд мэдээлэх, танилцуулах журам
- ❖ Зөрчлийн тухай хууль
- ❖ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

### Аудитын бүрэлдэхүүн, хугацаа


Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Билэгсайхан, Д.Эрдэнэбилэг, аудитор Т.Алтаншагай нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрийн хооронд хийж төлөвлөгөөг батлуулсан.

Талбарын үе шатны ажлыг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж дуусган, тайлан, судалгаа, дүгнэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

### Үндсэн мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд аймгийн ИТХ-д Хэнтий аймгийн Монгол ардын намын 1 хороо, 35 нэр дэвшигч, Хэнтий аймгийн Ардчилсан намын 1 хороо 35, Хүн намын 1 хороо, 6 нэр дэвшигч, Хэнтий аймгийн Иргэний хөдөлгөөний намын хороо, Хэнтий аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын хороог аймгийн Сонгуулийн хороонд бүртгүүлсэн байна.

Дүрслэл 1. Аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн дансны мэдээлэл, тайлан ирүүлсэн байдал



Сумдын Сонгуулийн хороонд сумдын Монгол ардын намын 18 хороо 381 нэр дэвшигч, сумдын Ардчилсан намын 18 хороо 383 нэр дэвшигч, Иргэний хөдөлгөөний намын 3 хороо, 11 нэр дэвшигч, бие даагч 1, нийт 776 нэр дэвшигч бүртгүүлсэн байна.

Үүнээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т заасны дагуу нийт 8 намын хороо, 835 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн байна.

Дүрслэл 2. Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн дансны мэдээлэл, тайлан ирүүлсэн байдал



Мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын хүрээнд 2 намын хороо, 812 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж ирүүлсэн байна.

**Бүлэг 1. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагад сонгуулийн дансаа бүртгүүлэх үүргээ нийт намын хорооны 79.5 хувь нь биелүүлээгүй, нэр дэвшигчдэд өгсөн зөвшөөрөгдөөгүй хандивын 48.3 хувийг буцаан шилжүүлээгүй байна.**

**1.1. Нийт нэр дэвшигчдийн 98 хувь нь сонгуулийн зардлын дансаа бүртгүүлж, дээд хэмжээнээс хэтэрсэн хандив аваагүй байна.**

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хүрээнд аймаг, сумын сонгуулийн хороонд нийт 44 намын хороо бүртгүүлснээс 9 намын хороо нь зардлын дансаа бүртгүүлсэн байна.

Харин аймаг, сумын Сонгуулийн хороонд бүртгүүлсэн 852 нэр дэвшигчээс 835 нэр дэвшигч Хаан банк, Хас банк, Төрийн банканд сонгуулийн данс нээн, дансны дугаараа аймаг дахь Төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

*Сонгуулийн зардлын дансаа бүртгүүлээгүй 35 намын хороо, 17 нэр дэвшигч нь АНСДИТХСТХуулийн 50.3. "Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй" гэсэн заалтыг биелүүлээгүй байна. /Хавсралт 4, 5/*

Сонгуулийн зардлын санхүүжилтийг АНСДИТХСТХуулийн хүрээнд бүрдүүлж ажилласан бөгөөд нийт 408 нэр дэвшигч 223.0 сая төгрөгийн хандивыг бүрдүүлсэн байна.

Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгийн хүрээнд Хэнтий аймгийн Хүн намаас 1 нэр дэвшигчид нийтдээ 4.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон бол бусад нэр дэвшигчдэд харьяалах намаас санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны аймаг, сумын ИТХ-д нэр дэвшигчдэд 969 иргэн, 2 хуулийн этгээд нийт 199.1 сая төгрөгийн хандив өгсөн нь АНСДИТХСТХуулийн 55.1<sup>1</sup>-т заасан хориглолтод хамаарахгүй байна.

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн 323 нэр дэвшигчдэд нийтдээ 197.6 сая төгрөгийн хандивыг 969 иргэн, 3 нэр дэвшигчдэд 1.5 сая төгрөгийн хандивыг 2 хуулийн этгээд хандивласан байна. Үүнээс 8 нэр дэвшигчдэд тус бүрд нь 2 сая төгрөгийн хандивыг 9 хандивлагч өгчээ. /Хавсралт 3/

*Нэр дэвшигчдэд АНСДИТХСТХуулийн 53.1<sup>2</sup>-т заасныг хэтрүүлэн хандив өгсөн иргэн, хуулийн этгээд байхгүй байна.*

<sup>1</sup> 55.1. Дараах этгээд хандив өгөхийг хориглоно:

55.1.1. гадаад улс буюу гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

55.1.2. гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;

55.1.3. 18 нас хүрээгүй хүн;

55.1.4. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

55.1.5. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;

55.1.6. үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага.

<sup>2</sup> 53.1. Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны сонгуульд нэр дэвшсэн 852 нэр дэвшигч мөнгөн бус хандиваар үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх гэрээг иргэн, хуулийн этгээдтэй байгуулаагүй байна.

**1.2. Хуульд заасан шаардлага хангаагүй нийт хандивын 48.3 хувийг буцаан шилжүүлэхгүй сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.**

АНСДИТХСТХуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаанд 403 нэр дэвшигч 222.9 сая төгрөгийг зарцуулж, 16 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын зарцуулалт

д/д	Сонгуулийн зардлын ангилал	Зардал /сая.төг/	Хувь
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	27.0	12.1
2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	0.2	0.1
3	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	-	0.0
4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	2.0	0.9
5	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	144.4	64.8
6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	0.5	0.2
7	Цахим орчин ашиглах зардал	1.0	0.4
8	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	0.4	0.2
9	Бусад зардал	47.4	21.3
	НИЙТ	222.9	

Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал буюу ухуулах байрны түрээс, ухуулагчийн цалин хөлс, урамшуулал, тээврийн хэрэгслийн зардал зэрэгт нийт зардлын 64.8 хувийг зарцуулсан байна.

Мөн сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах болон бусад зардалд 71.4 сая төгрөг буюу 33.4 хувийг зарцуулжээ.

АНСДИТХСТХуулийн 53.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.” гэж заасан байна.

Хуулийн дээрх заалтын шаардлагад нийцээгүй иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ гүйлгээний баримтад тусгаагүй нийт 466 иргэний 75.2 сая төгрөгийн хандив байгаагаас 216 иргэний 33,5 сая төгрөгийг хандивыг буцаан шилжүүлсэн бол 250 иргэний 41.7 сая төгрөгийн хандивыг сонгуулийн үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Үүнээс 131 нэр дэвшигч нь иргэний бүртгэлийн дугаарыг гүйлгээний баримтад тусгаагүй 222 иргэний 36,3 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй буюу АНСДИТХСТХуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийг зөрчсөн байна.

/Хавсралт 6/

Аймаг, нийслэл сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 51.1 “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно” гэж заасны дагуу данснаас дансанд шилжүүлж зарцуулсан боловч нийт 56 нэр дэвшигч 13.1 сая төгрөгийг өөрийн нэрийн данс руу шилжүүлж авсан байна.

Үүнийг сонгуулийн зардлын тайланд тусгахдаа сонгогчидтой уулзалт, хурал цуглаан хийх, цалин хөлс урамшууллын зардалд, тээврийн хэрэгслийн, сонгуулийн үйл ажиллагааны бусад зардалд гэсэн гүйлгээний утгатайгаар өөрийн данс нэрийн данс руу шилжүүлжээ.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/21 тушаалаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг, 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/22 тушаалаар Сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тус тус тогтоосон. Аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 32.7-84.9 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 26-31.3 сая төгрөгөөр, Сумдын ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 12.4-37.6 сая төгрөг байхаар тус тус тогтоосныг хэтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч байхгүй байна.

## **Бүлэг 2. Сонгуулийн зардлын тайланг хуулийн дагуу тайлагнасан байна.**

### **2.1. Нэр дэвшигчдийн 97.1 хувь нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн дагуу гаргаж ирүүлсэн бол намын хороодын 77.8 хувь нь сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.**

АНСДИТХСТХуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь заалтын дагуу аймгийн Сонгуулийн хороонд нэр дэвшихээр бүртгүүлсэн 44 намын хороо, 852 нэр дэвшигчээс 9 намын хороо, 835 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн.

Үүнээс мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтын дагуу 2 намын хороо, 812 нэр дэвшигч хуулийн хугацаанд хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан зардлын тайлангаа ирүүлсэн байна.

#### **Хүснэгт 2. Сонгуулийн зардлын тайланг ирүүлсэн нэр дэвшигчдийн тоо**

д/д	Намын нэр	Зардлын данс, банкны нэр бүртгүүлсэн нэр дэвшигчийн тоо	Зардлын тайлангаа баталгаажуулж ирүүлсэн нэр дэвшигчийн тоо
1	Ардчилсан нам	418	404
2	Монгол ардын нам	412	403
3	Хүн нам	5	5
	НИЙТ	835	812

**Сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргаж ирүүлээгүй 7 намын хороо, 23 нэр дэвшигч байна. /7, 8/**

Хуулийн дагуу хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны

А/34 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 17.1-т заасны дагуу хавсралт маягтыг бүрэн гаргаж ирүүлсэн боловч орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт, байгуулсан гэрээ хэлцлийн хуулбар зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг хангалттай хэмжээнд бүрдүүлж ирүүлээгүй байна.

## **2.2. Сонгуулийн зардлын тайланг баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг оролцогч талууд хууль, журмын дагуу гаргаж ирүүлсэн байна.**

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд нийт 5 аудитын хуулийн этгээд дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэсэн байна.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 20 дахь хэсэгт заасны дагуу ашиг сонирхлын хувьд нам, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан, ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдэгдэл, тайлбараа 3 хуулийн этгээд гаргаж ирүүлсэн.

*Хүснэгт 3. Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардалд дүгнэлт гаргасан аудитын хуулийн этгээдийн судалгаа*

Д/д	Хувийн аудитын хуулийн этгээдийн нэр	Дүгнэлт гаргуулсан		Мэдэгдэл тайлбар гаргасан эсэх
		Намын тоо	Нэр дэвшигчийн тоо	
1	“Ажу мэргэн аудит” ХХК		1	Тийм
2	“Ай Жи Эй Эйч-Аудит” ХХК		54	Тийм
3	“Нью капитал тэнцэл аудит” ХХК	1	5	Тийм
4	“Өлзийт экаунт аудит” ХХК		23	Үгүй
5	“Өндөрхаан итгэл-аудит” ХХК	1	729	Үгүй
	Нийт	2	812	

*“Өлзийт экаунт аудит” ХХК, “Өндөрхаан итгэл-аудит” ХХК нь ашиг сонирхлын хувьд нам, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан, ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдэгдэл, тайлбараа гаргаж ирүүлээгүй байна.*

Аймаг дахь Төрийн аудитын газраас Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг сануулж, сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн нэр дэвшигчдийн судалгааг хавсарган тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Голомт банк, Төрийн банк, Хаан банк, Хас банкны салбаруудад албан бичгийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн.

Үүний дагуу Голомт банк, Төрийн банк, Хаан банкнаас нам, нэр дэвшигчийн дансны хуулгыг гарган хуулийн хугацаанд багтаан ирүүлсэн.

*Хас банкны Хэнтий салбар нь нэр дэвшигчдийн сонгуулийн дансны хуулыг гаргаж ирүүлээгүй, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.*

### Аудитын дүгнэлт

- ✓ Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчдээс 35 намын хороо, 17 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаа Төрийн аудитын байгууллагад бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байна.
- ✓ Иргэн, хуулийн этгээдээс нэр дэвшигчдэд өгсөн хандив нь сонгуулийн тухай хуульд заасан хэмжээнээс хэтрээгүй байна.
- ✓ Сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргаж ирүүлээгүй 7 намын хороо, 23 нэр дэвшигч байна.
- ✓ Хас банкны Хэнтий салбар нь нэр дэвшигчдийн сонгуулийн дансны хуулгыг гаргаж ирүүлээгүй, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
- ✓ Хуульд заасан шаардлагад нийцээгүй 131 нэр дэвшигчдэд 222 иргэнээс хандивласан 36.3 сая төгрөгийг буцаан шилжүүлэлгүй хандив хүлээн авагч сонгуулийн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

## Тайланг баталгаажуулсан тушаал



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2025 оны 01 дугаар сарын 09

Дугаар А/01

Чингис хот

Г Аудитын тайлан Г  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт, МУЕА-ын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын газар, Хэнтий аймаг дахь Монгол банкны салбарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-т үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг олон нийтэд мэдээлэхийг ахлах аудитор /Ц.Билэгсайхан/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410001

## Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилтийн дүн

/мян.төг/

№	сум	Намын нэр	Нэр дэвшигчийн		Нэр дэвшсэн тойрог	Нийт санхүүжилтийн дүн	Санхүүжилтийн дүн							
			Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр			1.1 Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	Үүнээс:		1.4 Иргэний хандив	Үүнээс:	
										1.3.1 Мөнгөн хандив	1.3.2 Мөнгөн бус хандив		1.4.1 Мөнгөн хандив	1.4.2 Мөнгөн бус хандив
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
1	Аймгийн ИТХ	АН	Байгалмаа	Алтангэрэл	2	1,100.0			-		1,100.0	1,100.0		
2	Аймгийн ИТХ	АН	Мөнхжаргал	Мөнхбат	3	200.0			-		200.0	200.0		
3	Аймгийн ИТХ	АН	Солонго	Эрхэмбаяр	7	100.0			-		100.0	100.0		
4	Аймгийн ИТХ	АН	Гомбосүрэн	Ганхуяг	8	500.0			-		500.0	500.0		
5	Аймгийн ИТХ	АН	Төмөрбаатар	Энхчулуун	10	350.0			-		350.0	350.0		
6	Аймгийн ИТХ	АН	Төмөрбаатар	Батжаргал	11	1,020.0			-		1,020.0	1,020.0		
7	Аймгийн ИТХ	АН	Батмөнх	Цогт-Орших	14	0.5		0.5	-		-			
8	Аймгийн ИТХ	АН	Дамдин	Батболд	17	110.0			-		110.0	110.0		
9	Аймгийн ИТХ	АН	Даваадорж	Хүрэлбаатар	18	0.5		0.5	-		-			
10	Аймгийн ИТХ	АН	Амгаланбаатар	Жаргалсайхан	19	2,500.0		1,500.0	-		1,000.0	1,000.0		
11	Аймгийн ИТХ	АН	Батхуяг	Өнөрцолмон	19	1,388.9			-		1,388.9	1,388.9		
12	Аймгийн ИТХ	АН	Дүүхүү	Алтангэрэл	19	300.5		0.5	-		300.0	300.0		
13	Аймгийн ИТХ	АН	Амгалан	Боргил	20	2,330.5		0.5	-		2,330.0	2,330.0		
14	Аймгийн ИТХ	АН	Болдхуяг	Уранчимэг	20	840.5		0.5	-		840.0	840.0		
15	Аймгийн ИТХ	АН	Мөнхцэцэг	Чинбат	20	51.2			-		51.2	51.2		
16	Аймгийн ИТХ	АН	Даваажав	Эрдэнэбаатар	21	6,100.0			-		6,100.0	6,100.0		
17	Аймгийн ИТХ	АН	Шагдар	Жавхлан	21	800.5		0.5	-		800.0	800.0		
18	Аймгийн ИТХ	АН	Галбадрах	Хишигжаргал	21	680.0			-		680.0	680.0		
19	Аймгийн ИТХ	АН	Дэлэгдондов	Энхзаяа	22	50.8		0.8	-		50.0	50.0		
20	Аймгийн ИТХ	АН	Цэрэндагва	Амгаланбаатар	22	2,405.0			-		2,405.0	2,405.0		
21	Аймгийн ИТХ	АН	Энхбаяр	Одхүү	23	1,360.5		0.5	-		1,360.0	1,360.0		
22	Аймгийн ИТХ	АН	Баярсайхан	Бат-Орших	24	0.3		0.3	-		-			
23	Аймгийн ИТХ	АН	Жамбалсүрэн	Равжих	25	2,230.1		0.1	-		2,230.0	2,230.0		
24	Батноров	АН	Эрдэнэбат	Бадралмаа	1	1.0		1.0	-		-			
25	Батноров	АН	Наранчимэг	Баярцэнгэл	1	1.0		1.0	-		-			
26	Батноров	АН	Ганболд	Ариунбаяр	2	1.0		1.0	-		-			
27	Батноров	АН	Дамдиндорж	Батмөнх	2	1.0		1.0	-		-			
28	Батноров	АН	Намжил	Наранцэцэг	2	1.0		1.0	-		-			
29	Батноров	АН	Гомбо-Очир	Лхагвабаяр	2	1.0		1.0	-		-			
30	Батноров	АН	Энхбаяр	Баяртулга	3	1.0		1.0	-		-			
31	Батноров	АН	Цогбаяр	Тайванхүү	3	1.0		1.0	-		-			
32	Батноров	АН	Маналжав	Ган-Эрдэнэ	3	1.0		1.0	-		-			
33	Батноров	АН	Базаргүр	Цогтбаатар	3	1.0			-		1.0	1.0		
34	Батноров	АН	Мөнх	Баяржаргал	4	1.0		1.0	-		-			
35	Батноров	АН	Мөнхбат	Баярцэцэг	4	1.0		1.0	-		-			
36	Батноров	АН	Халтар	Баярцэцэг	4	1.0		1.0	-		-			
37	Батноров	АН	Буян	Ганболд	4	1.0		1.0	-		-			
38	Батноров	АН	Сайнбилэг	Хадбаатар	5	1.0		1.0	-		-			

39	Батноров	АН	Нэргүй	Энхбаатар	5	1.0		1.0	-		-		
40	Батноров	АН	Дашпүрэв	Баясгалан	6	1.0		1.0	-		-		
41	Батноров	АН	Дорж	Бямбацогт	6	1.0		1.0	-		-		
42	Батноров	АН	Гантөмөр	Отгонбаяр	6	1.0		1.0	-		-		
43	Батноров	АН	Ханджав	Баасанжав	7	2,000.5		0.5	-		2,000.0	2,000.0	
44	Батноров	АН	Лхагва	Сансарбаатар	7	50.0			-		50.0	50.0	
45	Батноров	АН	Батбаяр	Баттулга	7	600.0			-		600.0	600.0	
46	Батширээт	АН	Бэх-Очир	Хэрлэнчимэг	1	1,300.0			-		1,300.0	1,300.0	
47	Батширээт	АН	Борвоо	Сүхбаатар	1	150.0			-		150.0	150.0	
48	Батширээт	АН	Дугар	Мөнх-Онон	2	200.0			-		200.0	200.0	
49	Батширээт	АН	Лхам	Мөнхчулуун	3	1,001.0		1.0	-		1,000.0	1,000.0	
50	Батширээт	АН	Сандаг	Хандсүрэн	3	100.0			-		100.0	100.0	
51	Батширээт	АН	Бүслүүрдагва	Бадамгарав	4	140.0			-		140.0	140.0	
52	Батширээт	АН	Магван	Болд	4	308.0			-		308.0	308.0	
53	Батширээт	АН	Володя	Мөнхзул	4	120.0			-		120.0	120.0	
54	Батширээт	АН	Нямгэрэл	Маралгуа	4	210.0			-		210.0	210.0	
55	Батширээт	АН	Эрдэнэбилэг	Пүрэвжаргал	4	100.0			-		100.0	100.0	
56	Батширээт	АН	Болд	Төрмөнх	4	2,554.0			500.0	500.0	2,054.0	2,054.0	
57	Баян-Адарга	АН	Соёл-Эрдэнэ	Сугаррагчаа	3	100.0			-		100.0	100.0	
58	Баян-Адарга	АН	Батдагва	Довчинсүрэн	4	100.0			-		100.0	100.0	
59	Баян-Адарга	АН	Шаравдорж	Цэнджав	2	500.0			-		500.0	500.0	
60	Баян-Адарга	АН	Буриад	Андуу	4	1,035.0			-		1,035.0	1,035.0	
61	Баян-Адарга	АН	Дорж	Оюунчимэг	3	105.0			-		105.0	105.0	
62	Баян-Адарга	АН	Мөнх-Эрдэнэ	Мөнгөндолгио	1	40.0			-		40.0	40.0	
63	Баян-Овоо	АН	Агваанбалдан	Нямсүрэн	1	50.0			-		50.0	50.0	
64	Баян-Овоо	АН	Гонгор	Баасансүрэн	1	100.5			-		100.5	100.5	
65	Баян-Овоо	АН	Чулуунбаатар	Болор-Эрдэнэ	2	30.0			-		30.0	30.0	
66	Баян-Овоо	АН	Гүрцэдэн	Ар-Үр	2	50.0			-		50.0	50.0	
67	Баян-Овоо	АН	Догсомжав	Дунгаамаа	3	400.0			-		400.0	400.0	
68	Баян-Овоо	АН	Борной	Сарантуяа	4	100.0			-		100.0	100.0	
69	Баян-Овоо	АН	Гантөмөр	Сарантуяа	4	300.0			-		300.0	300.0	
70	Баян-Овоо	АН	Нямдорж	Энхсайхан	4	110.4		10.4	-		100.0	100.0	
71	Баян-Овоо	АН	Чулуунбаатар	Болд-Эрдэнэ	4	948.0			-		948.0	948.0	
72	Биндэр	АН	Намсрай	Ган-Од	1	0.5		0.5	-		-	-	
73	Биндэр	АН	Гадьбалдир	Отгонжаргал	1	1.0		1.0	-		-	-	
74	Биндэр	АН	Батсүх	Гэрэл	1	220.0			-		220.0	220.0	
75	Биндэр	АН	Цэнд	Базарсад	2	120.0			-		120.0	120.0	
76	Биндэр	АН	Чимэдцэеэ	Нямхүү	2	300.0			-		300.0	300.0	
77	Биндэр	АН	Энх-Амгалан	Сансартуяа	2	120.0			-		120.0	120.0	
78	Биндэр	АН	Гомбо-Аюуш	Энх-түвшин	2	600.0			-		600.0	600.0	
79	Биндэр	АН	Жамъяндоной	Ганзоригт	3	0.5		0.5	-		-	-	
80	Биндэр	АН	Лхагвасүрэн	Нарантуяа	3	0.5		0.5	-		-	-	
81	Биндэр	АН	Гэлэгжамц	Нарантуяа	3	0.5		0.5	-		-	-	
82	Биндэр	АН	Энхтайван	Мөнх-Очир	3	0.5		0.5	-		-	-	
83	Биндэр	АН	Түмэнбаяр	Азжаргал	4	0.5		0.5	-		-	-	
84	Биндэр	АН	Бадамжав	Баярмагнай	5	200.0			-		200.0	200.0	
85	Биндэр	АН	Түвшинжаргал	Гүрдорж	5	150.0			-		150.0	150.0	
86	Биндэр	АН	Сэр-Од	Болорцэцэг	5	100.0			-		100.0	100.0	
87	Биндэр	АН	Пүрэвдорж	Онончимэг	5	0.5		0.5	-		-	-	
88	Биндэр	АН	Болд	Тунгалаг	5	0.5		0.5	-		-	-	

89	Биндэр	АН	Дамбажунай	Аюурзана	5	500.5		0.5	-		500.0	500.0
90	Биндэр	АН	Солонго	Эрхэмбаяр	5	2,200.5		0.5	-		2,200.0	2,200.0
91	Бор-Өндөр	АН	Өлзийбаяр	Нарантуяа	1	20.5		20.5	-		-	
92	Бор-Өндөр	АН	Цогтбаатар	Өнөржаргал	4	160.0			-		160.0	160.0
93	Бор-Өндөр	АН	Оюунбаатар	Мөнгөнтуул	2	1.0		1.0	-		-	
94	Бор-Өндөр	АН	Отгон	Цогтбаяр	4	0.5		0.5	-		-	
95	Бор-Өндөр	АН	Баттөмөр	Болд	1	600.0			-		600.0	600.0
96	Бор-Өндөр	АН	Дашзэвэг	Ганбаатар	2	50.0			-		50.0	50.0
97	Бор-Өндөр	АН	Мөнх-Од	Мөнхгэрэл	1	550.0			-		550.0	550.0
98	Бор-Өндөр	АН	Энхбаяр	Гүржав	1	21.7		0.5	-		21.2	21.2
99	Бор-Өндөр	АН	Дэлгэрсайхан	Батсүх	3	20.5		0.5	-		20.0	20.0
100	Бор-Өндөр	АН	Жамбал	Нямаа	3	390.0			-		390.0	390.0
101	Бор-Өндөр	АН	Батсүх	Одсүрэн	2	0.5		0.5	-		-	
102	Бор-Өндөр	АН	Энх-Амгалан	Азжаргал	4	302.0			-		302.0	302.0
103	Галшар	АН	Наваандавга	Цолмондорж	1	0.5		0.5	-		-	
104	Галшар	АН	Лувсандаш	Магванхишиг	2	0.5		0.5	-		-	
105	Дадал	АН	Дагавсүрэн	Ганбат	3	100.0			-		100.0	100.0
106	Дадал	АН	Пүрэв	Уянга	3	51.0		1.0	-		50.0	50.0
107	Дадал	АН	Орсоо	Батсайхан	4	20.0		20.0	-		-	
108	Дадал	АН	Болдбаатар	Эрдэнэчулуун	4	50.0			-		50.0	50.0
109	Дадал	АН	Доржсүрэн	Энхбаяр	4	605.0		5.0	-		600.0	600.0
110	Дадал	АН	Гантөмөр	Чингэс	4	1,800.1		0.1	-		1,800.0	1,800.0
111	Дархан	АН	Ганбаатар	Батболд	1	0.4		0.4	-		-	
112	Дархан	АН	Жинчин	Эрдэнэчимэг	1	0.4		0.4	-		-	
113	Дархан	АН	Хуяг	Бат-Эрдэнэ	3	0.5		0.5	-		-	
114	Дэлгэрхаан	АН	Ганзориг	Ганхүлэг	2	50.0			-		50.0	50.0
115	Дэлгэрхаан	АН	Занаа	Ганбаатар	3	1,000.0			-		1,000.0	1,000.0
116	Дэлгэрхаан	АН	Лувсанбалдан	Мөнхбат	4	100.0			-		100.0	100.0
117	Дэлгэрхаан	АН	Энхбат	Сугар	5	20.0			-		20.0	20.0
118	Дэлгэрхаан	АН	Жагдаг	Энхцэцэг	5	50.0			-		50.0	50.0
119	Жаргалтхаан	АН	Доржсүрэн	Энхболд	1	440.0			-		440.0	440.0
120	Жаргалтхаан	АН	Батмөнх	Наранцогт	1	1.0		1.0	-		-	
121	Жаргалтхаан	АН	Санжид	Ундрал	2	0.5		0.5	-		-	
122	Жаргалтхаан	АН	Бавуудорж	Чинбат	3	1,400.0			-		1,400.0	1,400.0
123	Жаргалтхаан	АН	Санпилноров	Ганбат	3	100.0			-		100.0	100.0
124	Жаргалтхаан	АН	Мөнхтөр	Наранчимэг	5	1.0		1.0	-		-	
125	Мөрөн	АН	Гонгор	Дашпүрэв	4	500.5		0.5	-		500.0	500.0
126	Мөрөн	АН	Цагаан-Өвгөн	Мэгзэр	1	0.4		0.4	-		-	
127	Мөрөн	АН	Саруулдорж	Наран-Эрдэнэ	1	50.0			-		50.0	50.0
128	Мөрөн	АН	Амарсанаа	Энхбаяр	2	0.4		0.4	-		-	
129	Мөрөн	АН	Наранбаатар	Амармөрөн	2	0.4		0.4	-		-	
130	Мөрөн	АН	Сонин-Алдар	Энхсаруул	2	0.4		0.4	-		-	
131	Мөрөн	АН	Мягмарбаатар	Энхбаяр	3	0.4		0.4	-		-	
132	Мөрөн	АН	Сонин-Алдар	Энхсүх	4	0.4		0.4	-		-	
133	Мөрөн	АН	Ганхуяг	Оюунцэцэг	4	0.4		0.4	-		-	
134	Мөрөн	АН	Дорж	Нэргүй	5	0.4		0.4	-		-	
135	Норовлин	АН	Пүрэв	Энхтүвшин	2	100.0			-		100.0	100.0
136	Норовлин	АН	Арслан	Мөнхбайгаль	4	5,500.0			-		5,500.0	5,500.0
137	Норовлин	АН	Олигшоон	Пүрэвдулам	4	100.0			-		100.0	100.0
138	Норовлин	АН	Дашдорж	Мягмардаш	4	500.0			-		500.0	500.0

139	Өмнөдэлгэр	АН	Цэндсүрэн	Пүрэвдорж	1	170.0				-		170.0	170.0
140	Өмнөдэлгэр	АН	Ганболд	Эрдэнэсүвд	2	40.0				-		40.0	40.0
141	Өмнөдэлгэр	АН	Намжил	Ганбаатар	2	10.0				-		10.0	10.0
142	Өмнөдэлгэр	АН	Цэнд	Оуюн-Эрдэнэ	3	60.0				-		60.0	60.0
143	Өмнөдэлгэр	АН	Харууш	Болор-Эрдэнэ	4	110.0				-		110.0	110.0
144	Өмнөдэлгэр	АН	Жигжид	Мөнхжаргал	5	20.0				-		20.0	20.0
145	Өмнөдэлгэр	АН	Долгоржав	Энхбаатар	5	100.0				-		100.0	100.0
146	Өмнөдэлгэр	АН	Гомбодорж	Алтантуяа	5	105.0				-		105.0	105.0
147	Өмнөдэлгэр	АН	Рагчаабазар	Энхтөр	6	1,400.0				-		1,400.0	1,400.0
148	Хэрлэн	АН	Цэнджав	Цэрэндулам	1	0.3			0.3	-		-	-
149	Хэрлэн	АН	Хүдэрбаатар	Сайнхүү	1	0.5			0.5	-		-	-
150	Хэрлэн	АН	Наваанпэрэнлэй	Орхончимэг	1	1,290.5			0.5	-		1,290.0	1,290.0
151	Хэрлэн	АН	Энх-Амгалан	Отгонбаяр	1	1,282.6			1.0	-		1,281.6	1,281.6
152	Хэрлэн	АН	Магван	Хүрэлчулуун	1	0.3			0.3	-		-	-
153	Хэрлэн	АН	Батжаргал	Золбоо	2	1,710.0				-		1,710.0	1,710.0
154	Хэрлэн	АН	Лувсаншарав	Ганбаатар	2	2,700.5		2,500.5		-		200.0	200.0
155	Хэрлэн	АН	Жунай	Лхагвахатан	2	650.0				-		650.0	650.0
156	Хэрлэн	АН	Намжилдорж	Энхжаргал	2	100.3			0.3	-		100.0	100.0
157	Хэрлэн	АН	Лувсандорж	Арвинжаргал	2	55.6				-		55.6	55.6
158	Хэрлэн	АН	Ганболд	Галбадрах	3	200.5			0.5	-		200.0	200.0
159	Хэрлэн	АН	Батсайхан	Энхтайван	3	1,320.0				-		1,320.0	1,320.0
160	Хэрлэн	АН	Сэргэлэнцогт	Болор-Эрдэнэ	3	801.1			1.1	-		800.0	800.0
161	Хэрлэн	АН	Батжилхүү	Эрдэнэтуяа	3	730.0				-		730.0	730.0
162	Хэрлэн	АН	Жадамбаа	Майнбаяр	3	20.2			0.2	-		20.0	20.0
163	Хэрлэн	АН	Хүрэлбаатар	Ангарагсандуй	4	100.0				-		100.0	100.0
164	Хэрлэн	АН	Даваажид	Баттуяа	4	268.0				-		268.0	268.0
165	Хэрлэн	АН	Содов	Оюун-Эрдэнэ	4	1,600.1			0.1	-		1,600.0	1,600.0
166	Хэрлэн	АН	Гомбобаатар	Баярцэцэг	4	100.3			0.3	-		100.0	100.0
167	Хэрлэн	АН	Долгор	Билгээ	4	600.5			0.5	-		600.0	600.0
168	Хэрлэн	АН	Хусан	Аманбек	5	100.0				-		100.0	100.0
169	Хэрлэн	АН	Борхүү	Мөнхнаран	5	100.3			0.3	-		100.0	100.0
170	Хэрлэн	АН	Бүлтүүз	Дэлгэрцогт	5	150.3			0.3	-		150.0	150.0
171	Хэрлэн	АН	Бадрал	Мэндбаяр	5	350.0				-		350.0	350.0
172	Хэрлэн	АН	Цагаанлам	Мөнхсаруул	6	0.3			0.3	-		-	-
173	Хэрлэн	АН	Даржаа	Алтанчимэг	7	1,100.0				-		1,100.0	1,100.0
174	Хэрлэн	АН	Уртнасан	Алтангэрэл	7	20.0				-		20.0	20.0
175	Хэрлэн	АН	Халбак	Канат	8	0.3			0.3	-		-	-
176	Аймгийн ИТХ	МАН	Баатарцогт	Дарханбаатар	1	3,100.3		2,800.3		-		300.0	300.0
177	Аймгийн ИТХ	МАН	Дашцэрэн	Өлзийнаран	2	1,500.0				-		1,500.0	1,500.0
178	Аймгийн ИТХ	МАН	Лхамсүрэн	Бат-Октябрь	3	5,101.1			1.1	-		5,100.0	5,100.0
179	Аймгийн ИТХ	МАН	Баатарчулуун	Золжаргал	4	2,530.0				500.0	500.0	2,030.0	2,030.0
180	Аймгийн ИТХ	МАН	Ганхуяг	Энхзаяа	5	1,100.0				-		1,100.0	1,100.0
181	Аймгийн ИТХ	МАН	Лхамсүрэн	Мэндбаяр	7	200.0				-		200.0	200.0
182	Аймгийн ИТХ	МАН	Чулуунбаатар	Энхжавхлан	9	1,100.5			0.5	-		1,100.0	1,100.0
183	Аймгийн ИТХ	МАН	Батбаяр	Баттулга	11	450.0				-		450.0	450.0
184	Аймгийн ИТХ	МАН	Оюунбилэг	Анхбат	13	380.0				-		380.0	380.0
185	Аймгийн ИТХ	МАН	Гаваандамба	Төмөрбаатар	14	1,570.0				-		1,570.0	1,570.0
186	Аймгийн ИТХ	МАН	Түмэндэмбэрэл	Амартэмүүлэн	17	1,140.0				-		1,140.0	1,140.0
187	Аймгийн ИТХ	МАН	Мягмаржав	Шүрэнцэцэг	18	2,350.0				-		2,350.0	2,350.0
188	Аймгийн ИТХ	МАН	Даваадорж	Бат-Эрдэнэ	18	1,700.0				-		1,700.0	1,700.0

189	Аймгийн ИТХ	МАН	Баттулга	Энх-Эрдэнэ	19	1,200.0			-		1,200.0	1,200.0
190	Аймгийн ИТХ	МАН	Гансүх	Нэргүйбаатар	19	850.0			-		850.0	850.0
191	Аймгийн ИТХ	МАН	Сэлэнгэ	Ононбаяр	19	800.0			-		800.0	800.0
192	Аймгийн ИТХ	МАН	Гантөмөр	Хэрлэнчулуун	20	650.3		0.3	-		650.0	650.0
193	Аймгийн ИТХ	МАН	Бямбасүрэн	Мөнхбаяр	20	601.0		450.5	-		150.5	150.5
194	Аймгийн ИТХ	МАН	Дангаасүрэн	Алтаннамар	20	851.0		451.0	-		400.0	400.0
195	Аймгийн ИТХ	МАН	Цэнджав	Чогсомжав	21	1,500.0			-		1,500.0	1,500.0
196	Аймгийн ИТХ	МАН	Алтантөгс	Баярмаа	21	2,531.1			-		2,531.1	2,531.1
197	Аймгийн ИТХ	МАН	Оюун	Од-Эрдэнэ	21	1,878.9			-		1,878.9	1,878.9
198	Аймгийн ИТХ	МАН	Лхам	Батсайхан	22	4,030.0		2,500.0	-		1,530.0	1,530.0
199	Аймгийн ИТХ	МАН	Цэгмид	Эрдэнэцэцэг	22	1,850.0		500.0	-		1,350.0	1,350.0
200	Аймгийн ИТХ	МАН	Юмханд	Цогхүү	23	2,600.0			-		2,600.0	2,600.0
201	Аймгийн ИТХ	МАН	Хаянхярваа	Ганчулуун	24	3,620.0			-		3,620.0	3,620.0
202	Аймгийн ИТХ	МАН	Ширнэн	Шинэбаяр	25	50.0			-		50.0	50.0
203	Аймгийн ИТХ	МАН	Буян	Энхтайван	26	100.0			-		100.0	100.0
204	Батноров	МАН	Гомбо-Очир	Мөнхбат	1	910.0			-		910.0	910.0
205	Батноров	МАН	Сандагдорж	Эрдэнэбат	1	988.0			-		988.0	988.0
206	Батноров	МАН	Орос	Аюуш	2	800.0		500.0	-		300.0	300.0
207	Батноров	МАН	Гантулга	Төмөр-Эрдэнэ	2	800.0		100.0	-		700.0	700.0
208	Батноров	МАН	Туваанжав	Даваажав	2	800.0			-		800.0	800.0
209	Батноров	МАН	Хүрэлмөнх	Бэрцэцэг	2	1,550.0			-		1,550.0	1,550.0
210	Батноров	МАН	Баясгалан	Өсөхбаяр	3	700.0			-		700.0	700.0
211	Батноров	МАН	Батсуурь	Баасангунгаа	3	1,182.0			-		1,182.0	1,182.0
212	Батноров	МАН	Энхтайван	Эрдэнэбаяр	3	1,000.0			-		1,000.0	1,000.0
213	Батноров	МАН	Болд	Энхсайхан	3	602.0			-		602.0	602.0
214	Батноров	МАН	Пүрэвсүрэн	Лхагважав	4	1,120.5		0.5	-		1,120.0	1,120.0
215	Батноров	МАН	Мөнх	Амгаланбаатар	4	700.0			-		700.0	700.0
216	Батноров	МАН	Гүрдамдин	Энхболд	4	700.0			-		700.0	700.0
217	Батноров	МАН	Бат-Эрдэнэ	Наранцэцэг	4	700.0			-		700.0	700.0
218	Батноров	МАН	Баярцогт	Жавхланбаяр	5	1,000.0		1,000.0	-		-	
